



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/054/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал: Г.Энхмаа Утас: 99040059 Цахим хаяг: ijahaudit2020@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Төлбөрийн акт	8
3.2 Албан шаардлага	8
3.3 Зөвлөмж	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-05-13 № 851
танай _____ -ны № _____ -т

ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА
ЛОГИСТИКИЙН ТӨВ ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.БЯМБАСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 801.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 20.2.6 дэх заалтууд, Үнэн зөв байх, Тохиолдсон байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

1226050819
© Ulaanbaatar.gov.mn / Desktop Бичиг хэргэ 2025-05-13 10:00:00 AM

Аудитын гол асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2025 оны нийт орлогыг 4,757.5 сая төгрөг, нийт зардлыг 4,722.4 сая төгрөг, 35.1 сая төгрөгийн ашигтай ажиллагааг баталснаас гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 5,381.3 сая төгрөг, бусад үйл ажиллагааны орлого 17.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,506.5 сая төгрөгийг зарцуулж, 892.2 сая төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласан байна.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 хөтөлбөрийн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангалын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	1,387,040,940.07	2,470,746,103.77
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	260,161,397.64	1,136,912,230.58
1.1.2	Дансны авлага	634,059,215.44	878,134,076.03
	Татвар,НДШ-ийн авлага	2,429,790.46	50,409.96
	Бусад авлага	34,972,716.00	29,342,276.00
1.1.6	Бараа материал	124,084,365.98	165,591,495.74
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	331,333,454.55	260,715,615.46
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,387,040,940.07	2,470,746,103.77
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	58,761,771,775.15	58,455,381,264.95
1.2.1	Үндсэн хөрөнгө	12,233,163,775.15	11,926,773,264.95
1.2.2	Биет бус хөрөнгө	46,528,608,000.00	46,528,608,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	58,761,771,775.15	58,455,381,264.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	60,148,812,715.22	60,926,127,368.72
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	1,069,805,839.76	1,029,431,230.37
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	1,069,805,839.76	1,029,431,230.37
	Дансны өглөг	764,350,728.15	835,627,154.14
	Цалингийн өглөг	2,559,143.29	6,237,945.34
	Татварын өр	250,898,581.63	112,232,015.09
	Урьдчилж орсон орлого	51,997,386.69	75,334,115.80
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,069,805,839.76	1,029,431,230.37
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,069,805,839.76	1,029,431,230.37
2.3	Эздийн өмч	59,079,006,875.46	59,896,696,138.35
2.3.5	-хувийн	29,521,070,796.00	29,521,070,796.00
	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	33,288,739,667.00	33,288,739,667.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,005,129.80	16,005,129.80
2.3.9	Хуримтлагдсан ашиг(алдагдал)	(3,746,808,717.34)	(2,929,119,454.45)
2.3.11	Эздийн өмчийн дүн	59,079,006,875.46	59,896,696,138.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	60,148,812,715.22	60,926,127,368.72

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,306,987,358.89	5,381,324,890.90
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	53,788.74	
3	Нийт ашиг/алдагдал/	3,306,933,570.15	5,381,324,890.90
9	Хүүний орлого	285,154.67	17,439,894.91
10	Бусад орлого	7,714,545.45	
11	Борлуулалт, маркетингийн зардал	1,535,271,052.71	295,881,833.71
12	Ерөнхий ба удирдлагын зардал	1,922,067,562.77	4,207,396,322.22
14	Бусад зардал	45,969,510.47	3,214,704.00
20	Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал/	(188,374,855.68)	892,271,925.88
21	Орлогын албан татварын зардал	18,431.47	89,548,662.99
22	Татварын дараах ашиг алдагдал	(188,393,287.15)	802,723,262.89
24	Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/	(188,393,287.15)	802,723,262.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,658,973,807.48	5,915,219,690.45
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,622,804,441.65	5,894,265,677.25
1.1.4	Буцаан авсан албан татвар	28,454,820.38	
1.1.4	Бусад мөнгөн орлого	7,714,545.45	20,954,013.20
1.2	Мөнгөн зарлагын дүн	3,456,367,455.53	4,545,397,696.42
1.2.1	Ажиллагчдад төлсөн	970,449,868.71	1,772,478,983.17
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	284,933,356.68	228,886,429.14
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,779,992,143.42	637,246,290.36
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	11,338,000.00	405,804,138.78
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	23,399,372.73	9,093,685.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	245,521,933.20	935,629,939.64
1.2.9	Бусад мөнгөн зарлага	140,732,780.79	556,258,230.33
1.3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	202,606,351.95	1,369,821,994.03
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	285,154.67	17,439,894.91
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	285,154.67	17,439,894.91
2.2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,366,363.64	510,511,056.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,366,363.64	510,511,056.00
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,081,208.97)	(493,071,161.09)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	Валютын ханшийн зөрүү		
4	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	199,239,988.31	1,862,893,155.12
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,636,254.66	260,161,397.64
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	260,161,397.64	1,136,912,230.58

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,521,070,796.00	16,005,129.80	33,288,739,667.00	(3,746,808,717.34)	59,079,006,875.46
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				14,966,000.00	14,966,000.00
3	Залруулсан үлдэгдэл	29,521,070,796.00	16,005,129.80	33,288,739,667.00	(3,731,842,717.34)	59,093,972,875.46
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				802,723,262.89	802,723,262.89
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,521,070,796.00	16,005,129.80	33,288,739,667.00	(2,929,119,454.45)	59,896,696,138.35

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Харьцуулалт			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/2025гүйц	Хувь	2025 төл/2025гүйц	Хувь
Орлогын зүйл							
Авто зогсоолын түрээс	2,205,350.00	3,250,000.00	3,736,608.25	1,531,258.25	41.0	486,608.25	13.0
Контейнер байрлуулсаны орлого	9,109.09	15,000.00	6,018.18	(3,090.91)	-51.4	(8,981.82)	-149.2
Авто зогсоол ашиглалтын орлого	165,514.77	250,000.00	350,037.13	184,522.36	52.7	100,037.13	28.6
Өмчлөлтэй зогсоолын газрын төлбөр	23,522.19	33,000.00	7,781.38	(15,740.81)	-202.3	(25,218.62)	-324.1
Сурталчилгааны самбарын түрээс	1,276.36	2,400.00	5,020.91	3,744.55	74.6	2,620.91	52.2
Зөөврийн барилгын газар ашиглалт	350,475.17	480,000.00	505,325.01	154,849.84	30.6	25,325.01	5.0
Цахилгааны орлого	228,494.06	369,600.00	353,495.69	125,001.63	35.4	(16,104.31)	-4.6
Орох хаалганы тасалбарын орлого	279,831.07	300,000.00	342,834.33	63,003.26	18.4	42,834.33	12.5
Чанга яригч үзель	-	504.00	-	-		(504.00)	
Дугуй түгжигчийн орлого	11,398.13	16,200.00	36,172.91	24,774.78	68.5	19,972.91	55.2
Бусад орлого	32,016.52	40,800.00	38,031.09	6,014.57	15.8	(2,768.91)	-7.3
Цахим хуудаст баннер байршуулах 2 төрөл	-	-	-	-		-	
Үйл ажиллагааны бус орлого	7,999.70	-	-	(7,999.70)		-	
Нийт Борлуулалт	3,314,987.06	4,757,504.00	5,381,324.88	2,066,337.82	38.4	623,820.88	11.6
Зардлын зүйл							
Цалин	1,210,537.23	1,856,600.00	1,850,606.05	640,068.82	34.6	(5,993.95)	-0.3
НДШ	143,503.38	223,200.00	223,200.00	79,696.63	35.7	-	0.0
ТУЗ цалин	-	166,320.00	154,572.00	154,572.00	100.0	(11,748.00)	-7.6

Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Албан татвар хураамж /Машины татвар бусад/	1,151.86	960.00	2,300.06	1,148.20	49.9	1,340.06	58.3
Ашиглалтын зардал	378,502.96	420,000.00	541,865.42	163,362.46	30.1	121,865.42	22.5
Бичиг хэрэг	11,753.78	15,000.00	10,608.25	(1,145.53)	-10.8	(4,391.75)	-41.4
Шатахуун	21,926.56	30,000.00	21,178.68	(747.88)	-3.5	(8,821.32)	-41.7
Даатгалын зардал	-	1,200.00	214.81	214.81	100.0	(985.19)	-458.6
Сэлбэг хэрэгсэл тээвэр	10,955.45	11,040.00	8,182.07	(2,773.38)	-33.9	(2,857.93)	-34.9
Шуудан холбоо	43,926.30	49,800.00	48,735.83	4,809.53	9.9	(1,064.17)	-2.2
Сургалтын зардал	4,668.18	25,020.00	712.50	(3,955.68)	-555.2	(24,307.50)	-3411.6
Түрээсийн зардал /байр, тоног төхөөрөмж/	34,881.60	90,000.00	89,760.00	54,878.40	61.1	(240.00)	-0.3
Хангамжийн зардал	147,215.74	132,000.00	97,886.29	(49,329.45)	-50.4	(34,113.71)	-34.9
Хөдөлмөр хамгааллын зардал	28,986.59	32,400.00	17,622.72	(11,363.87)	-64.5	(14,777.28)	-83.9
Зар сурталчилгааны зардал	37,125.56	42,000.00	954.54	(36,171.02)	-3789.4	(41,045.46)	-4300.0
Томилолтын зардал	11,218.00	25,200.00	4,977.33	(6,240.67)	-125.4	(20,222.67)	-406.3
Засвар үйлчилгээний зардал	178,519.44	150,000.00	57,978.30	(120,541.14)	-207.9	(92,021.70)	-158.7
Элэгдлийн зардал	837,623.99	840,000.00	805,278.06	(32,345.93)	-4.0	(34,721.94)	-4.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	74,282.91	247,500.00	295,881.83	221,598.92	74.9	48,381.83	16.4
Газрын төлбөр	163,978.75	165,000.00	147,969.38	(16,009.37)	-10.8	(17,030.62)	-11.5
Бусад зардал	116,652.55	132,000.00	122,793.88	6,141.33	5.0	(9,206.12)	-7.5
Үйл ажиллагааны бус зардал	45,897.29	67,200.00	3,214.70	(42,682.59)	-1327.7	(63,985.30)	-1990.4
Нийт зардал	3,503,308.13	4,722,440.00	4,506,492.70	1,003,184.57	22.3	(215,947.30)	-4.8
Хүүгийн орлого	-	17,439.89	17,439.90	17,439.90	100.0	0.01	0.0
Татварын өмнөх ашиг/алдагдал	(188,374.86)	35,064.00	892,272.08	1,080,646.94	121.1	857,208.08	96.1
Орлогын албан татвар	18.43	3,506.40	89,548.68	89,530.25	100.0	86,042.28	96.1
Цэвэр ашиг/алдагдал	(188,393.29)	31,557.60	802,723.40	991,116.69	123.5	771,165.80	96.1

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,371,952.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 712.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 1,371,239.8 мянган төгрөгийн 5 албан шаардлага өгсөн.

Нийт илрүүлсэн 1,371,952.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,336,918.7 мянган төгрөгөөр их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тавигдаагүй.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тайлант хугацаанд 628,040.9 мянган төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцэст авлага, өглөгийн үлдэгдэлийг харилцагч байгууллага хувь хүнтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 86.7% буюу 26,691.1 мянган төгрөг, албан шаардлагын биелэлт 75.6% буюу 145,948.3 мянган төгрөгөөр дутуу хэрэгжсэн байна. Төлбөрийн акт 100% биелэлттэй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйл 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцох албан шаардлага өгөв.

3.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүнг ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүнтэй тулгахад ерөнхий журналд 712.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, хүчин төгөлдөр баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд 628,040.9 мянган төгрөгийн авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	628,040.9			1	628,040.9								
2	Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын дүн, Ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүн 712.5 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	712.5					1	712.5						
3	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 86.7% буюу 26,691.1 мянган төгрөг, албан шаардлагын биелэлт 75.6% буюу 145,948.3 мянган төгрөгөөр дутуу хэрэгжсэн байна. Төлбөрийн акт 100% биелэлттэй байна.	1	172,639.4							1	172,639.4				
	Дүн	3	801,392.8			1	628,040.9	1	712.5	1	172,639.4				

Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 334,336.0 мянган төгрөгийн 42 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	334,336.0			1	334,336.0		
Шилэн дансны хуулийн Нийт дүн	1	334,336.0			1	334,336.0		
Тайлант онд цахим дэлгүүрээс хүсэлт илгээж худалдан авалт хийлгүй 67,342.9 мянган төгрөгийн бараа материал, 91,965.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нийт 159,308.7 мянган төгрөгийн шууд худалдан авсан байна.	1	159,308.7			1	159,308.7		
Ажилтныг ажлаас чөлөөлсөн тушаал гаргах бүрд тэтгэмжийг 1-4 сараар олгож нийт 76,914.8 мянган төгрөгийн тэтгэмжийг хавтгайруулж олгосон байна.	1	76,914.8			1	76,914.8		
Төрийн хэмнэлтийн хуулийн нийт дүн	2	236,223.5			2	236,223.5		
Нийт дүн	3	570,559.5			3	570,559.5		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 536/10310473

Улаанбаатар хот

НТНГ-2026/054/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 628,040,874.83 /Зургаан зуун хорин найман сая дөчин мянга найман зуун далан дөрвөн төгрөг наян гурван мөнгө/ төгрөгийн авлага, өөр төлбөрийг тооцоо хийж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өр төлбөрийг тооцоо хийж, баталгаажуулаагүй зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн дарга (С.Бямбасүрэн), Ахлах нягтлан бодогч (Ө.Соёлмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Г.ЭНХМАА



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090913



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 532/102104.73

Улаанбаатар хот

НТМ-2026/054/НА-СТА-ОНӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 86.7% буюу 26,691,127.21 /Хорин зургаан сая зургаан зуун ерэн нэгэн мянга нэг зуун хорин долоон төгрөг хорин нэгэн мөнгө/ төгрөг, албан шаардлагын биелэлт 75.6% буюу 145,948,283.33 /Нэг зуун дөчин таван сая есөн зуун дөчин найман мянга хоёр зуун наян гурван төгрөг гучин гурван мөнгө/ төгрөг, нийт 172,639,410.54 / Нэг зуун далан хоёр сая зургаан зуун гучин есөн мянга дөрвөн зуун арван төгрөг тавин дөрвөн мөнгө/ төгрөгөөр дутуу хэрэгжүүлж ажилласан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах..", 19.2-д "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-д "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн Ерөнхий нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн дарга С.Бямбасүрэн-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Г.ЭНХМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090917



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 538/10210175

Улаанбаатар хот

ННАТ-2026/054/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 334,336,002.44 /Гурван зуун гучин дөрвөн сая гурван зуун гучин зургаан мянга хоёр төгрөг дөчин дөрвөн мөнгө/ төгрөгийн 42 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой ач холбогдолтой байх", Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3 дугаар зүйлийн 3.2-д "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээлэх мэдээллүүдийг хугацаа хороож мэдээлсэн зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн дарга (С.Бямбасүрэн), Ахлах нягтлан бодогч (Ө.Соёлмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Г.ЭНХМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090909



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 537/1021/473

Улаанбаатар хот

НТАГ-2026/054/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цахим дэлгүүрээс хүсэлт илгээж худалдан авалт хийлгүй 67,342,909.09 /Жаран долоон сая гурван зуун дөчин хоёр мянга есөн зуун есөн төгрөг есөн мөнгө/ төгрөгийн бараа материал, 91,965,772.75 /Ерэн нэгэн сая есөн зуун жаран таван мянга долоон зуун далан хоёр төгрөг далан таван мөнгө/ төгрөгийн үндсэн хөрөнгө буюу нийт 159,308,681.84 /Нэг зуун тавин есөн сая гурван зуун найман мянга зургаан зуун наян нэгэн төгрөг наян дөрвөн мөнгө/ төгрөгийн хөрөнгийг шууд худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим дэлгүүрт байршсан үндсэн хөрөнгө, бараа материалыг цахим дэлгүүрээс худалдан авалгүй шууд худалдан авсан зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн Гүйцэтгэх захирал (С.Бямбасүрэн), ахлах нягтлан бодогч (Ө.Соёлмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Г.ЭНХМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090910



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 531 / 10210473

Улаанбаатар хот

1771-2026 / 054 / 11А - СТА - 012047

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтныг ажлаас чөлөөлсөн тушаал гаргах бүрт тэтгэмжийг 1-4 сараар олгож нийт 76,914,803.0 / Далан зургаан сая есөн зуун арван дөрвөн мянга найман зуун гурван / төгрөгийн тэтгэмжийг хавтгайруулж олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл. 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тэтгэмжийг хавтгайруулан олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн дарга (С.Бямбасүрэн), Ахлах нягтлан бодогч (Ө.Соёлмаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЙ ЖЭЙ ЭЙ ЭЙЧ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Г.ЭНХМАА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090965

